



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Бага багтаамжийн автобусаар нийтийн тээврийн үйлчилгээг түр гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/431 дүгээр захирамж, 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь заалт, 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Захиргааны зөвлөлийн хурлын 12 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний буухиа чиглэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бага багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгүүлэх гэрээний үндсэн дээр түр хугацаанд ажиллуулж, эхний улирлын техникийн хяналтын үзлэгийн төлбөрөөс чөлөөлсүгэй.

2. Нийслэл хотын алслагдсан цэгүүдээс Нарантуул ОУХТөвд хүрч үйлчлэх буухиа чиглэлүүд, ажиллах тээврийн хэрэгслийн тоог тогтоохыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, бага багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангуулах үүднээс техникийн хяналтын үзлэгт улиралд 1 удаа хамруулж, зорчигч тээврийн аюулгүй байдлыг хангуулахыг Техникийн үзлэг, оношлогооны төв /Ц.Нанжид/-д, техникийн хяналтын үзлэгт тэнцсэн бага багтаамжийн автобусыг нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд шууд бүртгэн ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, бага багтаамжийн автобусаар нийтийн тээврийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, батлагдсан чиглэл, замналын дагуу явуулах, шугамын үйлчилгээний явц байдалд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус үүрэг болгосугай.

3. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжтэй хийх хоёр талт гэрээг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгуулж, үйлчилгээний даалгаврын хуудас олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, бага багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгийн хугацааг нарийвчлан гаргаж

холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулахыг Техникийн үзлэг, оношлогооны төв /Ц.Нанжид/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР